

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244805

МОНГОЛ ХЭЛНИЙ ҮЙЛИЙН БОЛОН ӨГҮҮЛБЭРИЙН ОРХИЛТ
(“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН”-Ы ЖИШЭЭГЭЭР)

Г.Баттогтох
Д.Бямбажаргал

Түлхүүр үг: холбоосжилт, орхилт, нэрийн орхилт, үйлийн орхилт, өгүүлбэрийн орхилт, Монголын нууц товчоон

Удиртгал

Хязгааргүй, бүхэл, уялдаат шинжтэй ертөнцийн юм үзэгдэл байгальд зэрэгцэн оршдог бол хүний хэлэнд дохио болон илэрхийлэгдэхдээ цуварч хэлэгддэг байна. Цуварч хэлэгдсэн санаа буюу өгүүлбэр нь юм үзэгдэл, түүний хөдөлгөөн, чанар, харьцааг багтаасан; өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн гэх төгс бус дохиог нийлүүлсэн төгс дохио юм. Төгс дохио-өгүүлбэр нь мөчлөгийг, мөчлөг нь цогцолборыг, цогцолбор нь хэлний олон янзын хэрэглүүрээр утга, хэлбэр, үүргийн давхарласан бүтэцтэй, харилцааны төгс дохио-эхийг бүтээнэ. Эх, өгүүлбэрийг төгс утгатай, зөв хэлбэржилттэй болгох нэгэн гол бүрдүүлбэр нь *холбоосжилт* (cohesion) болно.

Холбоосжилт, түүний нэгэн гол хэлбэр болох *орхилт* (ellipsis)¹-ын өгүүлбэр,

¹ Монгол хэл шинжлэлд *төгс бус өгүүлбэр, гүйцэд бус өгүүлбэр, заримдаг өгүүлбэр, дутмаг өгүүлбэр, өрөөсгөл өгүүлбэр, хагасармал өгүүлбэр, бүрэн бус өгүүлбэр* гэдэг нэр томъёо бүхий ойлголтын хүрээнд орхилтыг судлан шинжилж иржээ. Уг нэр томъёоны тухайд Ц.Сүхбаатар “Монгол хэлний найруулга зүйн нэр томъёоны тайлбар толь”-доо *ellipse* гэдэг нэр томъёог *хураангуйлал* гэж оноогоод “Энэ бол уран дүрслэлд чухал үүрэг бүхий өгүүлбэр зүйн ур маяг. Найруулга зүйд *орхилт* гэж нэрлэдэг. Учир шалтгааны шаардлагат гишүүн буюу бүрэлдэхүүн хэсгийг дутуу орхиж, ямар нэгэн нэмэлт дайвар өнгө ялгараа оруулах, баатрын сэтгэлийн хөдөлгөөнийг гаргах, эрчимжүүлэх, бууруулах, тансаг, тод, оновчтой болгох зорилго бүхий найруулгын ур маяг юм” (2003: 160) гэж тайлбарлажээ. М.Базаррагчаа нар “Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь”-доо гээх буюу хагасармал; *ellipse*; эллипсис (*гр. Elleipsis “алгасгах”*) гэсэн нэр томъёог “эхийн дотор хийгээд хэл ярианы тодорхой орчин нөхцөлөөр амархан сэргээгдэж болох үгийг /хэлний нэгжийг/ орхих үзэгдэл. *Өгссөн үү? Тийм ээ, өгссөн (шалгалт)*”. *What next?* гэсэн асуултыг “*What is / will be / could happen/ etc. Next*” гэж, *Mud on my shirt!* гэж уулга алдсаныг “*There’s / I’ve got mud on my shirt!*” (Carter, McCarthy 2007, 129) гэж сэргээх юм. Мөн *Я в магазин* (“*Я иду/бегу хожу г.м. в магазин*”). *Он испанский знает?* -*Знает (хэл).* *What did you buy?* – *A car (I bought a car)* (Гуревич 2004, 163). Ингэж гээх ёсыг харилцан ярианд ихэвчлэн хэрэглэх бөгөөд, мөн орлол үүсэх оньс болдог. Өгүүлэмжийг хөдлөнгө, амьд ярианы аялгатай, уран яруу болгох найруулгын ур маяг болгон ашигладаг ажээ. Жишээ нь, *Ангийн сурагчид нийтээрээ зугаалгад явжээ*

эхэд гүйцэтгэх үүргийг тодруулж, жишээгээр тайлбарлах зорилгоор энэхүү өгүүллийг бичив.

М.А.К.Халлидэй (M.A.K.Halliday), Рукайя Хасан (Ruqaiya Hasan); Робин Фаусет (Robin P.Fawcett), Батлер (C.S.Butler), Такер (G.Tucker), Кристофер (S.Christopher), Томсон (G.Thompson), Ж.Р.Мартин (J.R.Martin), Дэвид Рөүз (David Rose) зэрэг хэл шинжлэлч *Тогтолцоот үүргийн хэл шинжлэл, холбоосжилт, холбоос*-ыг судалсан юм. М.Халлидэй нар *холбоосжилтын хэлбэр*-ийг дараах байдлаар илэрхийлсэн байна.

Ерөнхий хэлбэр		Хэл зүйн бүс [(байр) хэл зүйн нэгж]	Үгийн сангийн бүс [Үгийн сангийн хэлбэр]
Хоорондын шилжилт		ХОЛБООС (Conjunction) [unit: clause] Нэгж өгүүлбэр	ҮГИЙН САНГИЙН ХОЛБООСЖИЛТ [ойролцоо, hyponymy] [давтамж, хам үг]
Элементийн байр	утгаар	ТӨЛӨӨЛҮҮЛЭЛ [unit: nominal: adverbial group] Нэгж: нэрлэсэн, дайвар үгийн	
	үгээр	ОРХИЛТ, ОРЛУУЛАЛ Нэгж: өгүүлбэр (нийлмэл) нэр үгийн, туслах үгийн]	

Холбоосжилтын хэлбэр (Types of cohesion)

М.А.К.Халлидэй “Хэл зүйн онолын ай” (Categories of the Theory of Grammar) хэмээх өгүүллийг “Үг” (Word) сэтгүүлд 1961 онд хэвлүүлсэн бөгөөд “Орчин үеийн хятад хэлний хэл зүйн ай” (Grammatical Categories in Modern Chinese) (1956/1976) номдоо анх дэвшүүлсэн ойлголтыг энэхүү өгүүлэлд тусгасан байна. М.А.К.Халлидэй, Рукайя Хасан нар *Тогтолцоот үүргийн хэл шинжлэл*-ийн онолын хүрээнд англи хэлний холбоосжилтын тогтолцоог боловсруулж, холбоосжилтыг дотор нь төлөөлүүлэл (reference), орлуулал (substitution), орхилт (ellipsis), холбоос (conjunction)², үгийн сангийн холбоосжилт (lexical cohesion)³ гэж ангилан судалжээ. Эдгээр судлаачдын *орхилт*-ын талаарх дэвшүүлсэн онол, саналыг монгол хэлний жишээ баримтаар тайлбарлах, өвөрмөц шинжийг тодорхойлох, зүй тогтлыг олж сургалт, судалгааны хүрээнд нэвтрүүлэх нь өгүүлбэр, эхийг ойлгох, бүтээх, задлан шинжлэхэд тус дөхөм болно.

– *Ангиараа зугаалгад явжээ. Галзуу улаан хэд хэд угзраад...* (галзуу улаан тамхиа) (2014: 82-83) гэж тайлбарласан байна. Бид *ellipsis* гэдэг ухагдахууны өгүүлбэр, эхэд гүйцэтгэх үүрэг, мөн чанар болон дээрх судлаачдын саналыг харгалзан үзэж, *орхилт* гэдэг нэр томъёог ашиглав.

² Г.Баттогтох тус сэдвээр 2023 онд “Орчин цагийн монгол хэлний холбоос” нэг сэдэвт судалгааны бүтээл бичсэн болно.

³ М.Маралмаа тус сэдвээр 2023 онд “Орчин цагийн монгол хэлний үгийн сангийн холбоосжилт” дипломын ажил бичсэн болно.

Орхилт бол эхийн холбоо хамаарлын хэсэг бөгөөд эхэд үг, өгүүлбэрийг дахин давтахгүй байх, цаг хэмнэх, сэтгэл хөдлөл илэрхийлэхийн тулд хэрэглэдэг. М.А.К.Халлидэй нар⁴ “Орлуулал ба орхилт нь өөр хоорондоо тун төстэй ойлголт юм. Орхилт бол тэгээр орлуулах арга тул уг хоёр ойлголтыг тус тусад нь авч үзэх аргагүй. Гэсэн хэдий ч орлуулал, орхилт нь эхийн суурь бүрдүүлэгч (утгын хувьд үг, өгүүлбэрийн хамаарлыг илтгэхдээ төлөөлүүлээс өөр) болох бөгөөд хоёр өөр төрлийн бүтцийн тогтолцоо, хэв маягийг харуулна. Орхилтын тухай өгүүлэхэд “хэлээгүй үлдээсэн зүйл”-тэй холбоотой ойлголт болно. “Орхисон зүйл юу байна вэ” гэдэг нь ойлгомжгүй хэрэг биш, харин ч тодорхой зүйл байдаг (1976: 142) гэж үзжээ. Тэд энэхүү саналаа *Үүргийн хэл зүйн удиртгал* бүтээлдээ лавшруулж өгүүлсэн байна (2014: 635). Түүнчлэн Ж.Томпсон “Орхилтыг бичвэрээс илүү харилцаа ярианд голлон хэрэглэдэг. Энэ нь хоёр талын харилцааны тодорхой хэлбэр болох хэлэлцээр өрнүүлэх, хамтын ажиллагааг тогтооход тусалдаг” (2014: 220) гэжээ. Эхэлж өгүүлсэн төгс санаа (өгүүлбэр), түүний бүрэлдүүлбэр (нэр үг, үйл үг)-ийг удаах өгүүлбэрт дахин өгүүлэхгүйгээр орхиж, тэг хэлбэр (Ø)-ээр илэрхийлэх байдлаар зохиомжилно. Орхилт нь тэг хэлбэрээр илэрч байгаа тул эхийн утга санааг алдуулахгүй бөгөөд зарим талаар уг зүйлд хандаж буй баймж, үнэлэмжийг илтгэнэ.

Орхилтыг хэлбэрээр нь гурван дэд хэсэгт хувааж үздэг. Үүнд:

1. Нэрийн орхилт. Жишээ нь:
Найман сурагч сургууль явсан, бас нөгөө хоёр нь номын сан явсан.
Найман сурагч сургууль явсан, бас нөгөө хоёр Ø нь номын сан явсан.
Найман сурагч сургууль явсан, бас нөгөө хоёр сурагч нь номын сан явсан.
2. Үйлийн орхилт. Жишээ нь:
Та өчигдөр Өвөрхангай аймаг руу явсан уу? Тийм.
Та өчигдөр Өвөрхангай аймаг руу явсан уу? Тийм, Ø.
Та өчигдөр Өвөрхангай аймаг руу явсан уу? Тийм, явсан
3. Өгүүлбэрийн орхилт. Жишээ нь:
Бат-Очир юу хийж байсан бэ? –Дасгал.
Бат-Очир юу хийж байсан бэ? –Дасгал Ø.
Бат-Очир юу хийж байсан бэ? –Бат-Очир дасгал хийж байсан.

Монгол хэл шинжлэлд *орхилт*-ыг өгүүлбэрийн түвшинд нэр томъёо оноон судалж, гол шинжийг нь тайлбарлах судалгаа 1930-аад оноос эхэлжээ. Ялангуяа, Ш.Лувсанвандан хэл зүйн бичиг, судалгааны цуврал өгүүлэлдээ *орхилт*-ын тухай шинэлэг санаа дэвшүүлж, монгол хэлний жишээ баримтаар тайлбарлаж байв. Тодруулбал, “Өгүүлбэрийн ямар ч гишүүн дан нэг үгээр байж болмуй. Хэд хэдэн үг холбогдож бүтсэн ч байж болмуй. Үлгэрлэвээс: “Би ном уншив” хэмээсэн нэгэн өгүүлбэрт энэ өгүүлбэрийн нэмсэн үг нь ном болмуй. Энд нэмсэн үгийг

⁴ М.А.К.Халлидэй нар орхилт, түүний төрлийг нарийвчлан судалсан бөгөөд “өгүүлбэрийн орхилт нь нөхцөл байдалтай холбоотой ойлголт юм. Ялангуяа, харилцаа ярианд *тийм*, *үгүй* гэсэн асуулт хариулт, асуух төлөөний үг бүхий үгээр орхилт илэрнэ. *Тийм*, *үгүй* гэдэг үг бүтэн өгүүлбэрийн орхилт болж, хариултын үүрэг гүйцэтгэнэ (2004: 563) гэж үзжээ.

нэг үгээр хэрэглэжээ. Гэтэл гагцхүү нэмсэн үгийн оронд хэд хэдэн үг холболдож нэмэлт үгийг санааг гаргах ёс баймуй. Үлгэрлэвээс: *Би нөхрөө ирсэнд баясмуй* хэмээсэн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн нь *би*, өгүүлэхүүн нь *баясмуй* болмуй. Энэ өгүүлбэрийг хэлэгчээс *Юунд баяснам Та?* хэмээн асууваас *Нөхрөө ирсэнд* хэмээн хариулах болмуй. Гэтэл “Нөхрөө ирсэнд” хэмээсэн нэгэн бүлэг үгс болбоос хэдийгээр гагцаар биеэ дааж утга төгсөөгүй мэт боловч нарийвчлан үзвээс утгын талаар харилцан нягт холбогдож дангаар тусгаар санаа хадгалсан тул утга төгссөн өгүүлбэр болоход тун хялбархан амуй. Жишээлбээс: өмнө дурдсан өгүүлбэрийг утга төгссөн өгүүлбэр болгоход “Нөхөр минь ирсэн” гэх буюу эсвэл “Миний нөхөр ирэв” хэмээсэн утга төгссөн өгүүлбэр болмуй. Үүнээс үзвээс өгүүлбэрийн нэг буюу нэг хэдэн энгийн үг нийлсэн гишүүнийг өөртөө өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн гэх мэтчилэн өгүүлбэрийн хамаг гишүүд бүрдсэн бүхэл бүтэн өгүүлбэр ч атугай орлон байж чадах амуй” (1939: 211-212). “Өгүүлбэрийн ямар ч гишүүн дан үгээр байж болно” гэдэг санаа нь *орхилт* гэдэг холбоосжилтын төгс санааг бүтээх хэрэглүүр болж буй гол шинжийг тайлбарласан, монгол хэлний өгүүлбэр судлалд уг ойлголтыг судлан шинжлэх эхлэлийг тавьсан судалгаа болно.

Үйлийн орхилт: Ш.Лувсанвандан “Орчин цагийн монгол хэлний үгэлбэрийн бүтцийг судлах тухай асуудалд” өгүүлэлдээ “Энгийн нийлмэл үгэлбэрийн эцсийн бус, эцсийн үгэлбэрийн үглэгдэхүүний цөм үгс нь нэг адил бараг тохиолддоггүй, хэрэв тохиолдвол тэр хоёр үглэгдэхүүнийг нэгтгэж, зэрэгцсэн үглэхүүнтэй энгийн үгэлбэр болгоно. Жишээлбэл, *Дамдин адуугаа усалж, Дамдин гэрээ нүүлгэлээ. Дамдин адуугаа усалж, гэрээ нүүлгэлээ* гэх мэт. Үүнчлэн энгийн нийлмэл үгэлбэрийн эцсийн ба эцсийн бус үглэхүүн нь адил үгээр байвал бас нэгтгэж, зэрэгцсэн үглэгдэхүүнтэй үгэлбэр болгож болно. Жишээлбэл, *Дамдин адуугаа усалж, Дугар хонио усаллаа. Дамдин, Дугар хоёр адуу, хонио усаллаа* гэх мэт. Энэ мэтээр үгэлбэрийг товчилж хураах ёс хэлэнд арвин дэлгэрч, нэг үгэлбэрээр хязгаарлахгүй урдах үгэлбэрт нь гарсан үгийг дараах үгэлбэрт нь давтахгүй хураах ёс ялангуяа асуулт, хариултад арвин тохиолдоно. Жишээлбэл, *Та хөдөөнөөс ирэв үү? – Тэглээ* гэж хэд хэдэн үгээр асуусан асуултад ганц үгээр хариулах удаа олон байдаг. Энэ бол хэлний арвилах зарчим болно” (2010: 293) гэж өгүүлсэн нь *товчлох*, *хэмнэх*, *орхих* аргын хэлбэр, хувилбарын талаар жишээгээр тайлбарласан, өмнөх судалгаа, саналаа лавшруулсан ажил болсон юм.

Түүхэн сурвалжийн хэл, түүний мэдээллийн бүтэц, холбомжийн онцлогийг судлан шинжлэх нь үндэстний хэл, сэтгэлгээний хэв маяг, өвөрмөц шинжийг тайлбарлах нэгэн арга болно. Ш.Чоймаа “МНТ-ы хэлийг олон талаас нь, үг хэллэг зарим өгүүлбэр, эхийн зарим хэсэг, зарим үгийн үгийн сангийн утга, үг бүтээх дагавар, үг хувилгах нөхцөл зэргийг улам бүр тогтолцоотой судлах зэргээр хэлний олон түвшинд нь судлах ажил эрчимтэй болж байхын хамт харь хэлээр орчуулах, эрдэм шинжилгээний латин галиг хийх, анхны монгол бичгийн эхийг тухайн үеийн үсгийн тиг, зөв бичих ёс, хэл зүйн онцлогоор нь сэргээх, орчин цагийн монгол хэлэнд дахин хөрвүүлж, эртний үг хэллэгийн тайлбар хийх, хожмын монгол түүхэн сурвалжуудтай эх бичиг судлалын үүднээс харьцуулах

гэх мэт судалгаа үргэлжлэн хийгдэж, судалгааны чанарын түвшин ч сайжирчээ” (2017б: 7) гэж өгүүлсэн байдаг нь сурвалжийн хэлийг судлахын ач холбогдлыг тайлбарласан хэрэг юм. Үүний тул Монголын нууц товчоон дахь “verbal ellipsis” буюу үйлийн орхилт, түүний зарим хэлбэрийг жишээгээр тайлбарлав.

Монголын нууц товчоонд үйлийн орхилт илрэхдээ эхэнд өгүүлсэн санааг удаах өгүүлбэрт орхих гэхээсээ илүү өгүүлбэрийн төгсгөлд илрэх өгүүлэхүүн гишүүн нь эхний өгүүлбэрт тэг хэлбэрээр илрэх тохиолдол элбэг ажиглагдаж байна. Жишээ нь:

§81: onan-nu tün dotora kebte’esü üjekdegü ke’ejü usun-u qarki-tur gedergü kebdejü buqa’u-ban usun huru’u urusqan ni’ur ile kebdeba (Rachewiltz 1972) [Ононы түн дотор хэвтвээс үзэгдэх хэмээж, усны харигт гэдрэг харж хэвтэж, бугуугаа усан уруу урсган, нүүр ил хэвтэв. Чоймаа, 2022: 40] Энэхүү эхийн “бугуугаа усан уруу урсган, нүүр ил хэвтэв” хэмээх төгс нэгжид буй *хэвтэв* гэх үйл үг нь *бугуугаа усан уруу урсган* гэсэн эхний өгүүлбэр тэг хэлбэрээр илэрсэн байна.

Үйлийн орхилт, түүний тэг хэлбэр болон нөхөн харуулсан жишээг дараах байдлаар загварчилж болно. Үүнд:

1. §81: onan-nu tün dotora kebte’esü üjekdegü ke’ejü usun-u qarki-tur gedergü kebdejü buqa’u-ban usun huru’u urusqan Ø ni’ur ile kebdeba (Rachewiltz 1972)⁵
2. §81: onan-nu tün dotora kebte’esü üjekdegü ke’ejü usun-u qarki-tur gedergü kebdejü buqa’u-ban usun huru’u urusqan [kebtebe] ni’ur ile kebdeba (Rachewiltz 1972)⁶

Монголын нууц товчоонд хэд хэдэн үйлийг орхиж, нэгэн өгүүлэхүүнд хураан өгүүлэх арга хэлбэрийг түгээмэл ашигладаг ажээ. Энэ нь тухайн зүйлд хандаж буй үнэлэмж, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх арга болж байна. Ялангуяа, аливаа хүнд сануулж хэлэх үг, зэмлэн тушаах санааг уг аргаар бүтээж иржээ. Жишээ нь:

§87: namayi хүнесү-’er keyisgen aldaba edö’e eke-ben de’ü-ner-iyen erin ot (Rachewiltz 1972) [Намайг үнсээр хийсгэн алдав. Эдүгээ эхээ, дүү нараан эрэн од! Чоймаа, 2022: 43]

1. §87: namayi хүнесү-’er keyisgen aldaba edö’e eke-ben Ø de’ü-ner-iyen erin ot (Rachewiltz 1972)⁷
2. §87: namayi хүнесү-’er keyisgen aldaba edö’e eke-ben [erin ot] de’ü-ner-iyen erin ot (Rachewiltz 1972)⁸

Энэхүү жишээнээс ажиглавал, “эхээ эрэн од, дүү нараа эрэн од” гэдэг давтаж хэлсэн үгийг “эхээ, дүү нараа эрэн од” хэмээн хурааж, нэг өгүүлэхүүнийг нь орхиж бичжээ.

⁵ Ононы түн дотор хэвтвээс үзэгдэх хэмээж, усны харигт гэдрэг харж хэвтэж, бугуугаа усан уруу урсган Ø, нүүр ил хэвтэв (Чоймаа, 2022: 40).

⁶ Ононы түн дотор хэвтвээс үзэгдэх хэмээж, усны харигт гэдрэг харж хэвтэж, бугуугаа усан уруу урсган хэвтэв, нүүр ил хэвтэв (Чоймаа, 2022: 40).

⁷ Намайг үнсээр хийсгэн алдав. Эдүгээ эхээ Ø, дүү нараан эрэн од! (Чоймаа, 2022: 43)

⁸ Намайг үнсээр хийсгэн алдав. Эдүгээ эхээ эрэн од, дүү нараан эрэн од! (Чоймаа, 2022: 43)

Монголын нууц товчоонд дараалж болсон үйл явдлын нэг өгүүлэхүүнийг орхиж өгүүлсэн хэд хэдэн өгүүлэмж ажиглагдав. Жишээ нь:

§103: büse-ben güjü'ün-dür- iyen erigelejü maqalai-ban qar-tur-iyān se'ejigelejü qar-iyān e[b]ce'ün-dür-iyen mö'ele[t]cū naran [jük] yisün-te sögö[t]cū saculi öci'üli ö[k]ba (Rachewiltz 1972) [бүсээ хүзүүндээн эрихлэж, малгайгаан гартаан сээжиглэж, гараа өвчүүндээн мөөлдөж, наран зүг есөнтээ сөгдөж, сацал, өчүүл өгөв. Чоймаа, 2022:52]

§103: büse-ben güjü'ün-dür- iyen erigelejü Q maqalai-ban qar-tur-iyān se'ejigelejü Q qar-iyān e[b]ce'ün-dür-iyen mö'ele[t]cū Q naran [jük] yisün-te sögö[t]cū saculi öci'üli ö[k]ba (Rachewiltz 1972)⁹

§103: büse-ben güjü'ün-dür- iyen erigelejü [saculi öci'üli ö[k]ba] maqalai-ban qar-tur-iyān se'ejigelejü [saculi öci'üli ö[k]ba] qar-iyān e[b]ce'ün-dür-iyen mö'ele[t]cū [saculi öci'üli ö[k]ba] naran [jük] yisün-te sögö[t]cū (saculi öci'üli ö[k]ba (Rachewiltz 1972)¹⁰

Уг жишээнээс ажиглавал, зан үйлийн дарааллыг өгүүлэхэд сүүлийн төгс санааны өгүүлэхүүнд бүх өгүүлэхүүнийг хураасан байна.

Монголын нууц товчоонд хоёр үйл явдлын харьцаа хөдөлгөөнийг нэгэнд нь багтааж өгүүлсэн зүйл хэд хэд ажиглагдав. Жишээ нь:

§147: cinggis-qahan ügülerün dayisun yabuqsan gü'ün alaqsan-iyān dayisurqaqsan-iyān beye-'en ni'uju kele-ben bucaju ayu[yu] (Rachewiltz 1972) [Чингис хаан өгүүлрүүн: “Дайсан явсан хүмүүн алснаа, дайсархснаа, биеэн нууж, хэлээ бухаж аюу байюу” Чоймаа, 2022: 52]

§147: cinggis-qahan ügülerün dayisun yabuqsan gü'ün alaqsan-iyān Q dayisurqaqsan-iyān Q beye-'en ni'uju kele-ben bucaju ayu[yu] (Rachewiltz 1972) [Чингис хаан өгүүлрүүн: “Дайсан явсан хүмүүн алснаа Q, дайсархснаа Q, биеэн нууж, хэлээ бухаж аюу (байюу)” Чоймаа, 2022: 52]

§147: cinggis-qahan ügülerün dayisun yabuqsan gü'ün alaqsan-iyān [ni'uju] dayisurqaqsan-iyān [ni'uju] beye-'en ni'uju kele-ben bucaju ayu[yu] (Rachewiltz 1972) [Чингис хаан өгүүлрүүн: “Дайсан явсан хүмүүн алснаа нууж, дайсархснаа нууж, биеэн нууж, хэлээ бухаж аюу байюу.” Чоймаа, 2022: 52]

Өгүүлбэрийн орхилт: Монгол хэл шинжлэлийн судалгаан дахь *өрөөсгөл үгүүлбэр, заримдаг үгүүлбэр, төгс бус үгүүлбэр, бүрэн бус өгүүлбэр* зэрэг ойлголт нь *орхилт*-той уялдана. Уг асуудлаар Ш.Лувсанвандан хэл зүйн бүтээл, өгүүлбэр судлалын өгүүллүүддээ цувралаар тайлбарласан байна. Тэрээр “Монгол хэлний зүйн сурах бичиг” (Үгүүлбэрийн зүй) бүтээлдээ “*Тийм, тэгнэ, үгүй, биш*” гэсэн үгс дан, дангаараа үгүүлбэрийн үүрэг гүйцэтгэж хэрэглэгдсэнийг *үгүүлбэр үг* гэнэ. Жишээбэл: 1. *Та өнөө орой манайд очих уу? – Тэгнээ (өнөө орой танайд*

⁹ Бүсээ хүзүүндээн эрихлэж Q, малгайгаан гартаан сээжиглэж Q, гараа өвчүүндээн мөөлдөж Q, наран зүг есөнтээ сөгдөж, сацал, өчүүл өгөв [Чоймаа, 2022:52].

¹⁰ Бүсээ хүзүүндээн эрихлэж сацал, өчүүл өгөв, малгайгаан гартаан сээжиглэж сацал, өчүүл өгөв, гараа өвчүүндээн мөөлдөж сацал, өчүүл өгөв, наран зүг есөнтээ сөгдөж, сацал, өчүүл өгөв [Чоймаа, 2022:52].

очно). Энэ танай ном уу? – Тийм (энэ миний ном). Энэ танай морь мөн үү? – Мөн (энэ манай морь). 2. Та өнөө орой манайд очих уу? – Үгүй (Би өнөө орой танайд очихгүй). Энэ танай морь биш биз? – Биш (Энэ миний морь биш). 3. Та өнөө орой манайд очоорой! – Заа (Би өнөө орой танайд очъё). Хэрэв тийм, тэгнэ, мөн, үгүй, биш, заа гэсэн үгүүлбэр, үгс давтан дэлгэрүүлсэн үгүүлбэрийнхээ өмнө орвол хоорондуур нь таслал буюу анхаарлын тэмдгээр зааглана. Жишээлбэл: 1. Та маргааш манайд очих уу? – Тэгнэ, би маргааш танайд очно. Чи долдугаар ангид суралцдаг уу? – Тийм, би долдугаар ангид суралцдаг. Энэ таны ном мөн үү? – Мөн, энэ миний ном байна. 2. Та маргааш манайд очих уу? – Үгүй, би маргааш танайд очихгүй. Чи долдугаар ангид суралцдаг уу? Үгүй, би зургадугаар ангид суралцдаг. Энэ таны харандаа юу? – Биш, энэ миний харандаа биш (2010: 172-173) гэж үндсэн хэлбэр, шинжийг нь тайлан тайлбарлажээ.

Ш.Лувсанвандан үгүүлбэр үг гэдэг нэр томъёог удаах судалгаанууддаа тэр бүр хэрэглээгүй бөгөөд заримдаг үгүүлбэр, дан үгүүлбэр, өрөөсгөл үгүүлбэр зэрэг нэр томъёо бүхий ойлголтын хүрээнд гүнзгийрүүлэн судалжээ. Тодруулбал, “Үгүүлэгдэхүүн, үгүүлэхүүн буюу түүний санааг нэвтрүүлэхэд чухал холбогдох аль нэг гишүүдийг дурдаагүй, гагцхүү хойдох, урдах үгүүлбэр буюу орчны байдлаас учир нь мэдэгдэх үгүүлбэрийг заримдаг үгүүлбэр гэнэ. Жишээлбэл: Хэн ирэв? Бат-Очир. Чи хаана очно? – Сургууль дээр. Та миний харандааг авсан уу? – Үгүй, би аваагүй. Хэн бэ? – Бат-Очир гэх мэт. Заримдаг үгүүлбэр нь ярианы хэлэнд ихээхэн тохиолдох бөгөөд дурдаагүй орхисон үгүүлбэр нь нөгөө үгүүлбэр буюу орчин тойрны байдлаас аяндаа мэдэгдэнэ (2010: 388), “Үгүүлбэр хэмээгч юу вэ?” өгүүлэлд “Гагцхүү үгүүлэгдэхүүн үгүүлэхүүн хоёроос бүтсэн үгүүлбэрийг хураангуй дан үгүүлбэр хэмээнэ. Жишээлбээс, Бороо оров. Ногоо ургав гэх мэт. Үгүүлэгдэхүүн, үгүүлэхүүн хоёроос гадна бас ч хоёрдугаар зэргийн гишүүд бүхий үгүүлбэрийг дэлгэрэнгүй дан үгүүлбэр гэнэ. Жишээлбээс, Сумын хурал эхлэв. Улаан туг хийснэ гэх мэт. “Угтаа үгүүлэгдэхүүн, үгүүлэхүүн хоёргүй үгүүлбэр гэж байхгүй. Гэвч хааяа хэлж байгаа, хэлэлцэж байгаа хүмүүсийн санаанд энэ хоёр чухал гишүүдийн аль нэгийг буюу хааяа хоёуланг санаандаа бодоод амандаа хэлэхгүй орхих зүйл бий. Ийм байдалтай үгүүлбэрийг өрөөсгөл үгүүлбэр, хэрвээ үгүүлэгдэхүүн үгүүлэхүүн хоёр гол гишүүд илэрхий гарч ирсэн үгүүлбэрийг гүйцэд үгүүлбэр гэнэ. Жишээлбээс, Чи хэзээ ирсэн бэ? – Би уржигдар ирэв. Одоо хаа очно? – Сургууль дээр очно. Таны нэр хэн бэ? – Самбуу. Үүнд: нэгдүгээр үгүүлбэр үгүүлэгдэхүүн үгүүлэхүүн хоёр илэрхий гарч ирсэн гүйцэд үгүүлбэр, хоёрдугаар нь мөн гүйцэд үгүүлбэр, гуравдугаар нь гагцхан үгүүлэхүүн бүхий тул өрөөсгөл үгүүлбэр, дөрөвдүгээр нь мөн өрөөсгөл үгүүлбэр, тавдугаар нь гүйцэд үгүүлбэр, зургаадугаар нь үгүүлэгдэхүүнгүй тул өрөөсгөл үгүүлбэр болно” (2010, 7: 157), “Монгол хэлний нийлмэл үгүүлбэрийн тухай асуудалд” өгүүлэлд “Бас заримдаа гишүүн үгүүлбэр нь үгүүлэгдэхүүнгүй байж болно. Жишээлбэл, Хөдөөнөөс морь авчирсан хүн ирэв. Маргааш орой гурван цагт манай сургууль дээр хуралтайг та нар мэдсэн үү? Машинаар хадсан өвсийг хураав гэх мэтчилэн. Үүнд гишүүн үгүүлбэрээр тодруулсан үг нь утгаараа уул гишүүн үгүүлбэрийн үгүүлэхүүнээр илэрсэн үйл байдлын эзэн байвал уул

гишүүн үгүүлбэр нь үгүүлэгдэхүүнгүй байна. Жишээлбэл, *Адуун дээрээс морь авчирсан хүн ирэв* гэх мэт. Бас уул гишүүн үгүүлбэр нь нэгэн бүрэлдэхүүнт үгүүлбэр байвал мэдээжийн хэрэг тусгайлан үгүүлэгдэхүүнгүй байна. Жишээлбэл, *Манай сургууль дээр маргааш хуралтайг мэдсэн үү?* гэх мэт. Мөн хойдох урдах үгнээс буюу орчны байдлаас утга нь тодорхой байвал утга нь зохих гишүүн үгүүлбэрийн үгүүлэгдэхүүнийг орхисон байж болно. *Уулнаас морин дээр авчирсан түлээг хашианд хураав* гэх мэт. Бас гишүүн үгүүлбэрийн үгүүлэгдэхүүн нь хойноо гурван биеийн аль нэгийг заасан *минь*, *чинь* гэж хамаатуулах үгтэй байвал уул гишүүн үгүүлбэрийн үгүүлэхүүнээр илэрсэн үйл байдлын эзэн нь тодорхой болж ирэх тул ийм гишүүн үгүүлбэрийн үгүүлэгдэхүүнийг заримдаа орхиж болно. Жишээлбэл, *Морио авчирсны нь би мэдсэнгүй (Батыг морио авчирсны нь би мэдсэнгүй)*” гэх мэт (2010, 7: 215). Дээрх бүтээлүүдэд дурдсан өгүүлбэр, түүний хэлбэрт холбогдох тайлбар, судалгаа нь төгс санааны бүтцийг задлан шинжилсэн, үндсэн загварыг тайлбарлаж, өгүүлбэр судлалд зайлбаргүй гүнзгийрүүлж үзэх сэдэв мөн болохыг тодорхойлсноороо ач холбогдолтой болжээ.

Ж.Төмөрцэрэн, Ш.Лувсанвандан нар “Өгүүлбэр нь зөвхөн харилцахад мэдэгдлийн нэгж болох төдийгүй бас хүний санаа бодлын бүрэлдэх сэтгэлийн янз бүрийн хөдөлгөөнийг илрүүлэхийн хэрэглүүр нь болдог. Хэл сэтгэхүйн нэгдлийн чухамхүү биелэл нь үүнд оршдог. Өгүүлбэр нь бас хүний сэтгэлэгтэй холбоотой байдаг. Гэвч (сэтгэлэг бүхэн өгүүлбэр байдаг боловч) өгүүлбэр бүхэн сэтгэлэг байх албагүй. Өгүүлбэрийн дээд хэмжээ нь хэдэн арван үгээр байж болох ба хамгийн бага хэмжээ нь ганц үгээр ч байж болно. Жишээ нь: *Та номын санд очих уу? Очно. Энэ Доржийн ном мөн үү? Мөн.* Дээрх өгүүлбэрийн байдалд *очно, мөн* гэдэг нь хэдийгээр ганц үг боловч бүхэл бүтэн өгүүлбэрийн санаагаар хэрэглэгджээ (Орчин цагийн монгол хэл зүй, 1966: 240), Гол төлөв харилцах ярилцах байдалд өгүүлбэрийн дотор аль нэгэн чухал үг буюу хэсэг үгийг дурдахгүй өнгөрснийг *төгс бус өгүүлбэр* гэнэ. Гэвч уг өгүүлбэрийг “дутмаг” буюу “төгс бус” болгосон гэж утгын хувьд үзэж болдоггүй байна. Учир нь урьдах хойдох үг өгүүлбэрийн байдлаас түүний утга санаа бүрэн бүтэн ойлгогддог ажээ. Аль нэгэн чухал гишүүн тэрүүхэн байдалд дутуу мэт байх нь найруулгын шаардлагаас болсон байдаг. Өөрөөр хэлбэл, тэр үгийг заавал хэлэхийн шаардлагагүй болсон. Ийм учраас төгс бус өгүүлбэр нь холбогдох өгүүлбэртэйгээ нөхцөлдөн барилдсан байдаг тул түүнээс салган үзэж болохгүй. Өгүүлбэрийн дотор аль ч гишүүн дутсан байж болох боловч гол төлөв тусагдахуун, байц, өгүүлэгдэхүүн гишүүн дутах нь олон тохиолдоно. Жишээ нь: *Чиний морь байна уу?* (миний морь) *байна. Өглөө сурагчид ирэв үү?* (өглөө) *хэн ч ирээгүй. Ах чинь шалгалтаа өгсөн үү?* (Ах шалгалтаа) *өгсөн. Энэ машинаар хэн явах вэ?* (Энэ машинаар) *бид нар* (явна). Ийнхүү төгс бус өгүүлбэрийн аль нэгэн дутагдсан гишүүнийг сэргээн гаргаж болдог байхад эзэн биегүй өгүүлбэрийн өгүүлэгдэхүүнийг сэргээн гаргаж болдоггүй юм (1966: 246). Энэхүү хэл зүйн бүтээлд Ш.Лувсанванданы судалгааны суурь зарчим, дэвшүүлж байсан саналыг үндэслэл болгосон юм. Дээрх хэсэгт дурдсан “төгс бус өгүүлбэр нь холбогдох

өгүүлбэртэйгээ нөхцөлдөн барилдсан байдаг тул түүнээс салган үзэж болохгүй” гэдэг санаа нь *орхилт*-ыг нийлмэл өгүүлбэр, эхийн түвшинд тайлбарлах учиртай гэдгийг илэрхийлнэ.

Б.Пүрэв-Очир, Ю.Мөнх-Амгалан, З.Гулираанз нар *бүрэн бус өгүүлбэр* гэдэг нэр томъёоны хүрээнд түүний хэв шинжүүд, *орхисон буюу нэрлээгүй гишүүдийг нь ярианы орчноос нөхөн сэргээж болдог бүрэн бус өгүүлбэр, хураасан бүрэн бус өгүүлбэр* гэсэн дэд сэдвийг судлан шинжилжээ. Тухайлбал, “Хэл зүйн хувьд байвал зохих зарим гишүүдийг нь хурааж, орхиж, нэрлээгүй боловч тэр гишүүдийг нь хэл ярианы орчин, хам сэдвээс нөхөн сэргээж болдог, утга, мэдээллийн талаасаа бүрэн өгүүлбэртэйгээ дүйх өгүүлбэрийг бүрэн бус өгүүлбэр гэнэ. Гол шинж нь мэдээллийн агуулга, утга зүйн шинжээрээ гүйцэд буюу хэлбэрийн хувьд зарим бүрэлдүүлбэр нь илрээгүй, гэхдээ түүнийг нь нөхөн хэлж, сэргээх тэмдэг (пропуск)-тай байдагт оршино” (1995: 42) гэжээ. Эдгээр судлаачид монгол хэлний бүрэн бус өгүүлбэр, түүний хэв шинжийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай талаар тус судалгаандаа дурдсан байна.

Монголын нууц товчоон дахь “clausal ellipsis” буюу өгүүлбэрийн орхилт, түүний зарим хэлбэрийг жишээгээр тайлбарлав.

тийм, үгүй (yes, no) орхилт: *Орхилт* нь эхийг холбох хэрэглүүр болохдоо *харилцаа яриа, туульсын болон жүжгсийн зохиол* зэрэг чөлөөт найруулга бүхий эхэд *асуулт, хариулт* буюу хураангуйлсан хэлбэрээр илэрнэ. Тэрхүү хураангуй хариу нь “Зэ” гэдэг үгээр илэрдэг ажээ. Жишээ нь:

§82: basa qarin bedereye ke’eldüküi-tür sorqan-sira ügülerün mün mün mör-i’er-ēn ese üjeksen qajar-ıyan üje’et qarin bedereye ke’eba je-gü ke’eldüba (Rachewiltz 1972) [бас “харин (буцан) бэдэрье” хэмээлдэхүйд, Сорхон шар өгүүллрүүн: “Мөн мөн мөрөөрөө эс үзсэн газраа үзээд, харин (буцан) бэдэрье” хэмээв. “Зэ” хэмээлдэв. Чоймаа, 2022: 41]

[бас “харин (буцан) бэдэрье” хэмээлдэхүйд, Сорхон шар өгүүллрүүн: “Мөн мөн мөрөөрөө эс үзсэн газраа үзээд, харин (буцан) бэдэрье” хэмээв. “**Зэ (Ө: мөн мөн мөрөөрөө эс үзсэн газраа үзээд, харин (буцан) бэдэрье)**” хэмээлдэв]. Асуулт, хариултын хэлбэрийг ажиглахад өгүүлэгч, харилцагчийн “тухайн зүйлийг зөвшөөрөх, батлах, дагах санаа” бүхий сэтгэл хөдлөл, үнэлэмж дүгнэлтийг илэрхийлэх хэрэглүүр болжээ.

Өмнөх асуулт, хариултад *нийлмэл өгүүлбэр*-ийг орхиж өгүүлсэн байсан бол уг үйл явдлын үргэлжлэлийг өгүүлсэн хэсэгт цогцолборыг орхиж холбосон байна.

§83: basa qarin bedereye ke’eldüküi-tür sorqan-sira basa ügülerün tayici’ut kö’üt ta gege’en caqa’an üdür gü[b]cin gü’ü aldaba edö’e qarangqui söni ker olqun bida basa mün mün mör-ıyer ese üje[k]sen qajar-ıyan üje’et qarin bedere’et tarqaju manaqar üdür ci’ulju erıye qa’a otqu tere buqa’utu gü’ün ke’eba je ke’e[1]düyü (Rachewiltz 1972) [бас “Сорхон Шар бас өгүүллрүүн: “Тайчууд хөвүүд та (та нар) гэгээн цагаан өдөр хөвчин хүмүүн алдав. Эдүгээ харанхуй шөнө хэр (хэрхэн) олохун, бид? Бас мөн мөн мөрөөр эс үзсэн газраа үзээд, харин (буцан) бэдрээд тархаж, манатар өдөр чуулж эрье, хаа одох тэр бугуут

хүмүүн!” хэмээв. “Зэ” хэмээлдэж... Чоймаа, 2022: 41] [...хэмээв. “Зэ (Ө: мөн мөн мөрөөр эс үзсэн газраа үзээд, харин (буцан) бэдрээд тархаж, манагар өдөр чуулж эрье, хаа одох тэр бугуут хүмүүн!)” хэмээлдэж...]. Үүнээс үзвэл орхилт нь харилцаа яриа бүтээх гол хэрэглүүр, цаг хугацаа хэмнэх, үнэлэмж хандлага илэрхийлэх арга болдог байна. Монголын нууц товчоонд буй өгүүлбэрийн орхилтыг “Зэ” гэдэг батлах утгатай үгээр илэрхийлэх 3 тохиолдол ажиглагдаж байна. Харин асуух үг, төлөөний үг бүхий хураангуй хэлбэр ажиглагдсангүй.

тийм/үгүй орхилтын хувилбар: Монголын нууц товчоонд тухайн үйл явдлыг үнэлж дүгнэсэн, сайшааж баталсан санаа бүхий өгүүлэмжийн зүйл хэд хэд ажиглагдав. Жишээ нь:

§146: sorqan-sira ügülerün bi dotora-'an bölen itkel setkijü büle'ei yekin ya'araju bi ya'araju urit ire'esü tayici'ut noyat minu qocoruqsan eme kö'ün adu'un ide'en-i minu хүнесү-'er geyisgekün tede ke'ejü ülü ya'aran edö'e qahan-dur-iyān neyilen idürejü ireba ba ke'eba kelemen bara'asu jöb ke'eba (Rachewiltz 1972) [Сорхон Шар өгүүлрүүн: “Би дотроон бүрэн итгэл сэтгэж бүлгээ. Яахан яарах. Би яарч урьд ирвээс, Тайчууд ноёд миний хоцорсон эм хөвүүн, адуун идээнийг минү үнсээр хийсгэх, тэд хэмээж, үл яаран, эдүгээ хаандаа нийлэн идэрч ирэв, ба (бид)”. Хэлэн барваас “Зөв” хэмээв. Чоймаа, 2022: 90]

[Сорхон Шар өгүүлрүүн: “Би дотроон бүрэн итгэл сэтгэж бүлгээ. Яахан яарах. Би яарч урьд ирвээс, Тайчууд ноёд миний хоцорсон эм хөвүүн, адуун идээнийг минь үнсээр хийсгэх, тэд хэмээж, үл яаран, эдүгээ хаандаа нийлэн идэрч ирэв, ба (бид)”. Хэлэн барваас “Зөв (Ө: Би яарч урьд ирвээс, Тайчууд ноёд миний хоцорсон эм хөвүүн, адуун идээнийг минь үнсээр хийсгэх, тэд хэмээж, үл яаран, эдүгээ хаандаа нийлэн идэрч ирэв, ба (бид))]. Асуулт, хариултын хэлбэрийг ажиглахад өгүүлэгч, харилцагчийн “тухайн зүйлийг зөвшөөрөх, батлах, дагах санаа” бүхий сэтгэл хөдлөл, үнэлэмж дүгнэлтийг илэрхийлэх хэрэглүүр болжээ.

Тогтолцоот үүргийн хэл шинжлэлийн онолын хүрээнд холбоосжилтыг орхилт, орлуулал, төлөөлүүлэл, үгийн сангийн холбомж, холбоос гэж ангилан судалж буй жишгээр монгол хэлний үйлийн орхилт, өгүүлбэрийн орхилтын тухай судалгааны суурь ойлголт, жишээг тайлбарлалаа. Монголын нууц товчоонд буй үйлийн орхилт, өгүүлбэрийн орхилтын зарим жишээнээс ажиглавал, хоёр үйл явдлын харьцаа хөдөлгөөнийг нэгэнд нь багтааж өгүүлсэн, дараалж болсон үйл явдлын нэг өгүүлэхүүнийг орхиж өгүүлсэн, эцэст өгүүлсэн санаанд буй үйл үгийг орхиж, эхний хэсэгт тэг хэлбэрээр илрүүлсэн зэрэг зүй тогтол; аливаа төгс санааг үнэлж дүгнэх, харилцагч талын сэтгэл хөдлөл, хандлага байдлыг илэрхийлж буй зүй тогтол ажиглагдаж байна.

Ном зүй

Монгол хэлээр

- Баттогтох, Г. (2023) *Орчин цагийн монгол хэлний холбоосын судалгаа*. Улаанбаатар. 1-2
- Зэвьямбуу, Ч., Базаррагчаа, М. (2014) *Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар. 888х.
- Лувсанвандан, Ш. (1939) *Монгол хэлний зүй*. Улаанбаатар. 211-212.
- Лувсанвандан, Ш. (1939) Үгүүлбэр хэмээгч юу вэ?, *Шинэ толь*, №1-2, Улаанбаатар, 1939, 44-51; *Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган*, 7: 157.
- Лувсанвандан, Ш. (1956) *Монгол хэлний зүйн сурах бичиг* (Үгүүлбэрийн зүй); *Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган*, 3: 172-173.
- Лувсанвандан, Ш. (1957) Монгол хэлний нийлмэл үгүүлбэрийн тухай асуудалд. *Багш*, №2, 1957, 15-25; *Багш*, №3, 6-14; *Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган*, 7, 2010: 215.
- Лувсанвандан, Ш. (1977) Орчин цагийн монгол хэлний үгэлбэрийн бүтцийг судлах тухай асуудалд. *Хэл зохиол судлал*, XII: 3-33; *Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган*, 7: 267-295.
- Лувсанвандан, Ш. 1978. Хэлний өнгөн ба гүн бүтцийн тухай асуудалд. *Studia Mongolica*, V(13): 55-60; *Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган*, 7: 309-313.
- Пүрэв-Очир, Б., Мөнх-Амгалан, Ю., Гулираанз, З. (1995) *Монгол хэлний энгийн өгүүлбэр, эхийн онол-практикийн асуудал*. Улаанбаатар. 39-52
- Сүхбаатар, Ц. (2003) *Монгол хэлний найруулгазүйн нэр томъёоны тайлбар*. Улаанбаатар.
- Төмөрцэрэн, Ж. (1966) *Орчин цагийн монгол хэл зүй*, Улаанбаатар. 246
- Чоймаа, Ш. 2017. Монголын нууц товчооны хэлийг судлах тухай асуудалд. *Монгол хэл, бичиг, соёл судлал*, *Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган*. 2: 7-15.

Англи хэлээр

- Halliday, M.A.K., Hasan, Riquaiya. 1976. *Cohesion in English*. London: Longman.
- Halliday, M.A.K., & Matthiessen, C. M. I. 2014. M. Halliday's *Introduction to Functional Grammar (Fourth Edition)*. London and New York: Routledge. 608
- Thompson, G. 2014. *Introducing Functional Grammar (Third Edition)*. London and New York: Routledge. 225
- Эх сурвалж
- Чоймаа, Ш. (2022). *Монголын нууц товчоон* (Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг). Болор судар хэвлэлийн газар.
- Rachewiltz, Igor de. (1972) *Index to the Secret History of the Mongols*. Bloomington: Indiana University Publications.

Abstract

M.A.K.Halliday and Riquaiya Hasan studied the system of the cohesion, published 'Cohesion in English', which included substitution, ellipsis, conjunction, and lexical cohesion. Linguists developed within the framework of Systemic Functional Grammar (SFG) theory, also studied the cohesions of languages and are publishing many more research works. According to the theory, it is necessary to study the cohesion of the Mongolian language, and its meaning in the text. We explained examples of verbal ellipsis and clausal ellipsis in the 'The Secret History of Mongols' from the cohesions in Mongolian language.